



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас:70433061 Цахим хаяг:
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим
хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батзул

Утас:70432545 Цахим хаяг: batzul.n@audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
3.2 Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах асуудал:.....	9
3.3 Зөвлөмж	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

АОУС Аудитын Олон Улсын Стандарт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026-02-25 № 117
танай 2026-01-20-ны № 29 -Т

ХОВД АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН
ДАРГА Х.БАТЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.Үүнд:

- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн арга хэмжээг Засаг даргын захирамж, түүний хавсралтад тусгасан зориулалтын дагуу зарцуулаагүй 10.0 сая төгрөг,
- Татварын улсын байцаагчийн сарын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг шалгуур үзүүлэлт, босго тогтоохгүй хавтгайруулж олгосон 198.7 сая төгрөг,
- Татварын газрын гадна хаяг 2024 онд гүйцэтгэх компани руу шилжүүлж бараа материалын бүртгэлд авсан боловч гэрээний дагуу ажлаа бүрэн гүйцэт хийгээгүй 2.4 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн.

8426050386

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн нийт зардлын дүн өмнөх оноос 138.8 сая төгрөгөөр буурсан нь хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох дэмжлэгтэй холбоотой зардал буурсан нь нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 33 дугаар тушаал, Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журмын дагуу Татварын улсын байцаагч нарт 198.7 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Ховд аймгийн Татварын газар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 53 ажил, арга хэмжээ төлөвлөн Татварын ерөнхий газраас үнэлэгдэж ирээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,277,075.52</u>	<u>56,081,614.30</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	88,277,075.52	56,081,614.30
354	Хангамжийн материал	88,277,075.52	56,081,614.30
35410	Бичиг хэргийн материал	2,657,980.00	1,474,560.00
35440	Түлш, шатах тослох материал	1,550.00	1,550.00
35470	Бусад хангамжийн материал	85,617,545.52	54,605,504.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,229,406,565.57</u>	<u>1,192,754,973.32</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,229,406,565.57	1,192,754,973.32
392	Биет хөрөнгө	1,195,527,565.57	1,158,875,973.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,394,414,000.00	1,394,414,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	233,622,905.75	268,902,746.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,000,000.00	115,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	115,000,000.00	115,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	297,306,289.73	321,281,142.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	272,912,643.15	296,643,585.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,128,400.00	13,128,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	8,309,096.18	9,770,589.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	130,567,700.00	130,567,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	125,044,179.08	125,198,347.78
393	Биет бус хөрөнгө	33,879,000.00	33,879,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	33,879,000.00	33,879,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,317,683,641.09</u>	<u>1,248,836,587.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>10,461,781.50</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	10,461,781.50
413	Өглөг	-	10,461,781.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	82,500.00
4136	Бусад өглөг	-	10,379,281.50
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		10,379,281.50
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,317,683,641.09</u>	<u>1,238,374,806.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,317,683,641.09	1,238,374,806.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	356,656,848.00	356,656,848.00
51101	Өмч: - төрийн	356,656,848.00	356,656,848.00
512	Хуримтлагдсан үр дүн	961,026,793.09	881,717,958.12
51210	Өмнөх үеийн үр дүн	1,037,954,562.62	949,918,457.80
51220	Тайлант үеийн үр дүн	(88,036,104.82)	(79,308,834.97)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	11,108,335.29	11,108,335.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,317,683,641.09</u>	<u>1,248,836,587.62</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,720,445,600.00	2,588,844,397.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,607,000.00	24,044,862.43
120	Нийтлэг татварын бус орлого	15,607,000.00	24,044,862.43

Ховд аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,099,000.00	24,044,852.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,704,838,600.00	2,564,799,535.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,704,838,600.00	2,564,799,535.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,653,201,000.00	2,506,799,144.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	51,637,600.00	58,000,391.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,808,481,704.82	2,668,153,232.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,808,481,704.82	2,668,153,232.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,555,974,706.28	2,599,972,459.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,958,257,601.19	2,036,750,230.62
210101	Үндсэн цалин	873,856,646.22	963,289,691.62
210102	Нэмэгдэл	547,401,096.09	629,895,510.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,186,641.62	88,515,000.00
210104	Урамшуулал	448,813,217.26	355,050,029.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,737,655.64	252,206,579.90
210201	Тэтгэврийн даатгал	171,429,755.64	172,963,788.32
210202	Тэтгэмжийн даатгал	18,327,000.00	19,392,251.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,163,500.00	9,905,348.10
210204	Ажилгүйдлийн даатгал	9,163,500.00	9,905,348.10
210205	Эрүүл мэндийн даатгал	36,653,900.00	40,039,844.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,455,383.43	92,684,075.49
210301	Гэрэл, цахилгаан	3,581,246.95	4,268,521.78
210302	Түлш, халаалт	53,953,764.48	77,374,426.71
210303	Цэвэр, бохир ус	5,920,372.00	11,041,127.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,513,910.00	61,490,841.22
210401	Бичиг хэрэг	18,902,100.00	16,791,340.00
210402	Тээвэр, шатахуун	10,167,000.00	4,313,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,799,760.00	957,550.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	237,500.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,407,550.00	39,308,351.22
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,062,200.00	-
210604	Урсгал засвар	1,062,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	21,295,000.00	7,022,000.00
210702	Дотоод албан томилолт	21,295,000.00	7,022,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,145,568.00	88,992,288.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,882,000.00	88,540,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,616,970.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,400.00	114,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210807	Газрын төлбөр	522,198.00	337,688.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,507,388.02	60,826,444.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,507,388.02	60,626,444.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,506,998.54	68,180,772.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	219,826,166.00	67,943,443.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	49,671,443.77
213207	ХОН тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	217,186,166.00	17,772,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,680,832.54	237,328.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,680,832.54	237,328.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(88,036,104.82)	(79,308,834.97)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(88,036,104.82)	(79,308,834.97)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,037,954,562.62	1,405,719,745.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,037,954,562.62	1,405,719,745.91
C07	Тайлант үеийн үр дүн			(88,036,104.82)	(88,036,104.82)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	949,918,457.80	1,317,683,641.09
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	949,918,457.80	1,317,683,641.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	949,918,457.80	1,317,683,641.09
D08	Тайлант үеийн үр дүн			(79,308,834.97)	(79,308,834.97)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	870,609,622.83	1,238,374,806.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,704,838,600.00	2,565,952,139.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,704,838,600.00	2,565,952,139.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,704,838,600.00	2,564,799,535.00
131001	Урегал үйл ажиллагааны санхүүжилт	2,653,201,000.00	2,506,799,144.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	51,637,600.00	58,000,391.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,152,604.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1,152,604.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,704,838,600.00	2,565,952,139.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,704,838,600.00	2,565,952,139.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,452,331,601.46	2,496,618,762.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,957,997,244.39	2,002,540,699.71
210101	Үндсэн цалин	873,128,455.42	999,787,198.13
210102	Нэмэгдэл	547,401,096.09	567,233,842.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,186,641.62	88,082,214.00
210104	Урамшуулал	448,813,217.26	347,437,444.75
210105	Гэрээт ажлын хөлс	467,834.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,737,655.64	276,036,829.32
210201	Тэтгэврийн даатгал	171,429,755.64	195,308,031.19
210202	Тэтгэмжийн даатгал	18,327,000.00	20,192,399.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,163,500.00	10,096,199.31
210204	Ажилгүйдлийн даатгал	9,163,500.00	10,088,099.68
210205	Эрүүл мэндийн даатгал	36,653,900.00	40,352,099.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,455,383.43	92,684,075.47
210301	Гэрэл, цахилгаан	3,581,246.95	4,268,521.76
210302	Түлш, халаалт	53,953,764.48	77,374,426.71
210303	Цэвэр, бохир ус	5,920,372.00	11,041,127.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,872,470.00	20,304,900.00

Ховд аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210401	Бичиг хэрэг	5,652,000.00	4,780,200.00
210402	Тээвэр, шагахуун	10,167,000.00	4,313,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,799,760.00	875,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	237,500.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,016,210.00	10,216,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,547,200.00	362,500.00
210604	Урсгал засвар	9,547,200.00	362,500.00
2107	Томилолт, зочны зардал	9,547,200.00	7,022,000.00
210702	Дотоод албан томилолт	9,547,200.00	7,022,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,427,568.00	89,242,288.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,164,000.00	88,790,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,616,970.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,400.00	114,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210807	Газрын төлбөр	522,198.00	337,688.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,999,080.00	8,425,470.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,999,080.00	8,425,470.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,506,998.54	69,333,376.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	219,826,166.00	69,096,047.77
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	1,152,604.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	49,671,443.77
	ХОН тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	217,186,166.00	17,772,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,680,832.54	237,328.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,680,832.54	237,328.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
222001	Тоног төхөөрөмж	-	-
213404	Хөрөнгийн		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,559,794,000.00	2,506,631,815.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,559,794,000.00	2,506,631,815.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,491,850,500.00	2,438,688,371.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,003,631,900.00	1,959,428,440.71
210101	Үндсэн цалин	1,022,087,900.00	956,674,939.13
210102	Нэмэгдэл	610,854,400.00	567,233,842.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,363,200.00	88,082,214.00
210104	Урамшуулал	276,326,400.00	347,437,444.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	271,148,700.00	271,148,697.31
210201	Тэтгэврийн даатгал	190,419,900.00	190,419,899.19
210202	Тэтгэмжийн даатгал	20,192,400.00	20,192,399.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,096,200.00	10,096,199.31

Ховд аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	10,088,100.00	10,088,099.67
210205	Эрүүл мэндийн даатгал	40,352,100.00	40,352,099.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,057,500.00	92,684,075.49
210301	Гэрэл, цахилгаан	4,389,700.00	4,268,521.78
210302	Түлш, халаалт	78,346,500.00	77,374,426.71
210303	Цэвэр, бохир ус	12,321,300.00	11,041,127.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,589,200.00	20,134,900.00
210401	Бичиг хэрэг	7,093,900.00	4,850,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,313,600.00	7,313,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,184,500.00	875,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	807,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,190,200.00	6,976,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	639,600.00	362,500.00
210604	Урсгал засвар	639,600.00	362,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,998,200.00	4,022,000.00
210702	Дотоод албан томилолт	7,998,200.00	4,022,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,120,500.00	89,242,288.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,875,000.00	88,790,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	749,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,300.00	114,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	43,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	716,700.00	-
210807	Газрын төлбөр	519,000.00	337,688.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,665,500.00	1,665,470.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,665,500.00	1,665,470.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,943,500.00	67,943,443.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,943,500.00	67,943,443.77
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,671,500.00	49,671,443.77
213207	ХОН тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,772,000.00	17,772,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,559,794,000.00	2,506,631,815.28
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,559,794,000.00	2,506,631,815.28
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,559,794,000.00	2,506,631,815.28
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,637,600.00	58,000,391.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,637,600.00	58,000,391.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,637,600.00	58,000,391.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,051,200.00	43,112,259.00
210101	Үндсэн цалин	20,262,226.00	43,112,259.00
210102	Нэмэгдэл	5,788,974.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,256,400.00	4,888,132.00
210201	Тэтгэврийн даатгал	3,256,400.00	4,888,132.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,700,000.00	3,240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,700,000.00	3,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	-

210604	Урсгал засвар	10,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,630,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,630,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	6,760,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	6,760,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,637,600.00	58,000,391.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,637,600.00	58,000,391.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,637,600.00	58,000,391.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		70,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 221,824.39 мянган төгрөгийн зөрчил илэрснээс хуулийн байгууллагад 10,790.0 мянган төгрөгийн 2 асуудлыг шалгуулахаар МУЕА-т уламжлах, 10,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 201,115.39 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 221,824.39 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давсан төдийгүй шинж чанарын хувьд материаллаг алдаа илэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: ОНХС-н хөрөнгөөр санхүүжсэн арга хэмжээг Засаг даргын захирамж, түүний хавсралтад тусгасан зориулалтын дагуу зарцуулаагүй 10,000.0 мянган төгрөгийг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16-дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д зааснаар "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах асуудал:

Илрүүлэлт: Санхүүгийн тайлан баталгаажуулах явцад дараах 2 асуудал илэрсэн нь гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй тул хуулийн байгууллагад шалгуулах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

1. ОНХС-н хөрөнгөөр санхүүжсэн арга хэмжээг Засаг даргын захирамж, түүний хавсралтад тусгасан зориулалтын дагуу зарцуулаагүй, хуурамч баримт бүрдүүлэн 10,000.0 мянган төгрөгийг нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн дансаар дамжуулан бэлнээр гарган авч бусад үйл ажиллагаанд зарцуулсан.
2. 2024-2025 онуудад иргэний дансаар дамжуулан хамаарал бүхий этгээд, аж ахуйн нэгжээс мөнгөн орлого бүрдүүлсэн байж болзошгүй.

Шийдвэрлэсэн: Хуулийн байгууллагад шилжүүлэх.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1 Цалин урамшуулалтай холбоотой

Илрүүлэлт: Татварын улсын байцаагчийн сарын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 198,715.39 мянган төгрөгийг шалгуур үзүүлэлт, босго тогтоохгүй хавтгайруулж олгосон, унаа хоолны нэмэгдлийг сум, аймгийн төвд жигд олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16-дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Байгууллагын дотоод журмын 8.3-д зааснаар "Ажилтан, албан хаагчид ажилд ирэх, буцах унааны зардал 1000-6000 төгрөг, хоолны зардал 2000-8000 төгрөгийг ажилласан өдрөөр тооцож сар бүр олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын улсын байцаагчийн сарын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг байцаагчийн хариуцсан ажлын үр дүнд, гүйцэтгэлд үндэслэн үнэлж олгох, унаа хоолны нэмэгдлийг дотоод журамд нийцүүлэн батлагдсан төсөвтөө тааруулан олгох.

3.3.2 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын газрын гадна хаягийг 2024 онд 2,400.0 мянган төгрөг гүйцэтгэх гэрээ байгуулан хүлээн авч бараа материалын бүртгэлд авсан боловч одоог хүртэл гэрээний дагуу ажлаа хүлээн аваагүй, ажлын гүйцэтгэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний дагуу дутуу ажлуудыг гүйцэтгэгч байгууллагаар бүрэн хийлгэж, комисс томилон хүлээн авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	9	10					11	12
1	ТУБ-н сарын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг шалгуур үзүүлэлт, босго тогтоохгүй хавтгайруулж олгосон, Унаа хоолны нэмэгдлийг сум, аймагт жигд олгоогүй.	1	198,715.39	1	198,715.39						
2	2024-2025 онуудад иргэн, албан хаагчдын дансаар дамжуулан хамаарал бүхий этгээд, аж ахуйн нэгжээс мөнгөн орлого бүрдүүлсэн байж болзошгүй.	1	10,709.0							1	10,709.0
3	ОНХС-н хөрөнгөөр санхүүжсэн арга хэмжээг Засаг даргын захирамж, түүний хавсралтад тусгасан зориулалтын дагуу зарцуулаагүй,	1	10,000.0					1	10,000.0		
4	Татварын газрын гадна хаяг 2024 онд гүйцэтгэх компани руу шилжүүлж бараа материалын бүртгэлд авсан боловч гэрээний дагуу ажлаа бүрэн гүйцэт хийгээгүй.	1	2,400.0	1	2,400.0						
	Нийт дүн	4	221,824.39	2	201,115.39			1	10,000.0	1	10,709.0

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			0	1		
	НИЙТ	1	1			0	1		